

**“ШАТАХУУНЫ ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДААНЫ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ
(SIFS) ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ**
/2012 оны эцсийн байдлаар/

Монголбанкнаас жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар санхүүжүүлэхийн зэрэгцээ хил дээрх өртгийн ханшаас хамаарах нөлөөллийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор SIFS дэд хөтөлбөрийг Уул уурхайн яамтай хамтран 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж байгаа билээ.

Хүснэгт 1. Хөтөлбөрийн санхүүжилт

№	ААН-ийн нэр	Олгосон зээл	
		Огноо	Дүн (сая төгрөг)
1	Жаст-Ойл ХХК	11.27.2012	7,122.2
2	Монпетекс ХХК	11.29.2012	8,511.0
3	Содмонгол ХХК	12.03.2012	11,143.7
4	Магнай трейд ХХК	12.04.2012	14,642.8
5	Шунхлай ХХК	12.06.2012	21,363.8
6	Магнай трейд ХХК	12.07.2012	13,929.6
7	Содмонгол ХХК	12.10.2012	5,525.9
8	Монсуль ХХК	12.14.2012	278.6
9	Рысжан ХХК	12.14.2012	975.1
10	Ойн бирж ХХК	12.28.2012	7,283.8
11	Синчи Ойл ХХК	12.28.2012	975.1
12	Ундарга Увс ХХК	12.28.2012	975.1
13	Хөрс Автосервис ХХК	12.28.2012	975.1
Дүн			93,701.6

2012 оны эцсийн байдлаар нийт 9 удаагийн транчаар 11 хэрэгжүүлэгч компанид **3.8%**-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай **93.7** тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

Түүнчлэн дэд хөтөлбөрт заасны дагуу Монголбанк нь хөтөлбөрт оролцогч банкуудаар дамжуулан 11 компанитай нийт **94.0** тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг **2-6** сарын дараа худалдах форвард хэлцлийг хамгийн бага зардлаар гүйцэтгэлээ (*хүснэгт 2*).

Хүснэгт 2. Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцэл

№	Харилцагчийн нэр	Огноо	Хугацаа /хоног/	Форвард ханш	Худалдан авах валют дүн (сая төгрөг)
1	Жаст ойл ХХК	11.27.2012	59	1,397.4	7,118.2
2	Монпетекс ХХК	11.29.2012	60	1,398.3	8,511.0
3	Сод Монгол ХХК	12.03.2012	60	1,398.8	4,196.3
4	Сод Монгол ХХК	12.03.2012	120	1,399.7	4,199.1
5	Сод Монгол ХХК	12.03.2012	182	1,399.9	2,799.7
6	Магнай трейд ХХК	12.04.2012	62	1,399.5	14,695.1
7	Шунхлай ХХК	12.06.2012	60	1,403.5	21,386.3
8	Магнай трейд ХХК	12.07.2012	60	1,403.1	14,031.2
9	Сод Монгол ХХК	12.10.2012	60	1,402.5	5,563.6
11	Монсуль ХХК	12.14.2012	56	1,396.0	279.2
10	Рысжан ХХК	12.14.2012	56	1,396.0	977.2
12	Синчи Ойл ХХК	12.28.2012	60	1,393.3	975.3
13	Хөрс Автосервис ХХК	12.28.2012	60	1,393.3	975.3
14	Ундарга Увс ХХК	12.28.2012	60	1,393.3	989.2
15	Ойн бирж ХХК	12.28.2012	120	1,394.2	7,290.5
Нийт					93,987.1

Дээрх арга хэмжээний үр дүнд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч компаниуд (i) жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнээ хямд зардлаар санхүүжүүлж, **зээлийн хүүгээс шалтгаалсан өртгөө бууруулах нөхцөл бүрдсэн**, (ii) нефтийн төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой **ханишийн эрсдлээ бууруулсан** байна.

Дэд хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны **“Үнийг тогтворжуулах хөтөлбөр”** цэснээс үзнэ үү.